



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/216

Улаанбаатар хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Түр хамгаалах байранд стандартын шаардлага хангасан хяналтын камер суурилуулж, хохирогчийн болон үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Д.Оюунгэрэл)-т үүрэг болгосугай.

2. Камержуулалтад зарцуулагдах 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ КАМЕРЖУУЛАЛТАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	NVR дүрс бичлэг хадгалах төхөөрөмж	ширхэг	1	1,800,000	1,800,000
2	Дагалдах хэрэгсэл			1,000,000	1,000,000
Нийт зардал					2,800,000